



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/75

ӨвТ

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.5.7, 3.5.8, 3.6.1, 3.6.16 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 10-ний өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн 4 дүгээр багийн төвд ногоон байгууламж барих хашааны зардалд 1,950,000 (нэг сая ерөн зуун тавин мянган) төгрөг, сумын төвийн нийтийн хог цэвэрлэгээний хог тээвэрлэх шатахууны зардалд 567,720 (таван зуун жаран долоон мянга долоон зуун хорин) төгрөг, хог цэвэрлэгээний бусад зардалд 463,000 (дөрвөн зуун жаран гурван мянган) төгрөг, хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хяналт шалгалтын шатахууны зардалд 1,070,610 (нэг сая далан мянга зургаан зуун арван) төгрөг, нийт 4,051,430 (дөрвөн сая тавин нэгэн мянга дөрвөн зуун гучин) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 4,051,430 (дөрвөн сая тавин нэгэн мянга дөрвөн зуун гучин) төгрөгийг Байгаль хамгаалах сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

62 201 155

C:My Doc A-4 zahiramj /Zasag darga/